

The ADB logo consists of the letters 'ADB' in a white, serif font, centered within a dark blue square. A thin white vertical line is positioned to the right of the square.


ADB

# ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАРЫН ТАНИЛЦУУЛГА

МОН 9701, МОН 3843, МОН 3844  
ТӨСӨЛ

Тусламж, үйлчилгээний багц хариуцсан зөвлөх  
Ж.Гэрэлмаа

2022 он



	Орон нутаг	Нийслэл
ТӨЭМБ	33	41
ХХЭМБ	91	106
Сувилал	27	21
Эмийн сан	893	838
ӨСТЭМТ	393	133
Нийт	1438	1139



### Хуулийн өөрчлөлт

Төсвийн тухай хуулиар анхан шатны санхүүжилтийг орон нутгаар дамжуулахаа больсон



### ЭМДҮЗ 2020 оны 05 дугаар тогтоол

Чанар, төлбөрийн хяналтын зарчим өөрчлөгдөж, шинэчлэгдсэн.



### ЭМДСангийн хязгаарлагдмал нөөц, бодлогын зохицуулалт

Сангийн нөөцөд тохируулан, хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд суурилан гэрээгээр Т.Ү-ий тоо хэмжээг тохирох шаардлага



### Хариуцлагыг дээшлүүлэх

- ЭМБ
- ЭМДЕГ

## 10 дугаар зүйл. Даатгалын гэрээ байгуулах

10.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь энэ хуулийн 16.1.4-т заасны дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон эмийн сантай даатгалын гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г байгуулах бөгөөд **гэрээний хэрэгжилтийг хянаж, дүгнэнэ.**

10.2. Гэрээнд энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний **зардлын төсөв**, **нэр төрөл**, **тоо хэмжээ**, **чанарын шалгуур үзүүлэлт**, **төлбөрийн арга**, **төлбөрийн хэмжээ** болон **гэрээний хугацаа**, **талуудын хүлээх үүрэг**, **хариуцлага**, **гэрээг цуцлах нөхцөлийг** тодорхой тусгасан байна.

10.3. Гэрээний үлгэрчилсэн **загварыг Үндэсний зөвлөл** батална.

3.1.8.“даатгалын гэрээ” гэж эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хооронд байгуулсан гэрээг;

11.3.Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг төсвийн сарын хуваарийг үндэслэн гүйцэтгэлээр тооцож олгох бөгөөд эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан **гэрээний дагуу зардлын урьдчилгаа төлбөр олгож болно.**


16.1.3.даатгуулагчийг төлөөлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай тусламж, үйлчилгээ худалдан авах даатгалын **гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх**

20.1.3.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг харгалзан даатгалын гэрээтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч **байгууллагад олгох урамшууллын зардал;**





- 01** ОУ-ын жишигт нийцүүлэх
- 02** МУ-ын хууль эрх зүйд нийцүүлэх
- 03** ЭМДЕГ-ын шинэчилсэн бүтэц, чиг үүрэгтэй уялдуулах
- 04** Тодорхойгүй байдлаас үүдэлтэй хэрэгжилтэнд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх
- 05** Гэрээ байгуулагч талуудад ойлгомжтой болгох



1. Нийтлэг зүйлс
2. Талуудын эрх үүрэг
3. Гэрээнд өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх
4. Гэрээг цуцлах, дуусгавар болгох
5. Хариуцлага
6. Гэрээг дүгнэх
7. Маргаан шийдвэрлэх
8. Гэрээ хүчин төгөлдөр болох

Гэрээгээр:

- **Тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь:** Хүний эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд анагаах ухааны нотолгоонд суурилсан аргаар, чанартай, аюулгүй, шуурхай үзүүлэх,
- **Худалдан авагч нь:** иргэн-даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээг “чанарын болон төлбөр”-ийн хяналт, гүйцэтгэлд үндэслэн худалдан авахтай холбогдох харилцааг зохицуулна.

**Талуудын үйл ажиллагаанд мөрдөх Хууль эрх зүй:**

- Захиргааны Ерөнхий хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- Холбогдох бусад хууль, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталсан журам заавар
- Энэхүү гэрээ





## Гэрээний баримт бичиг:

1. тусламж, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, төлбөрийн хэмжээг тогтоосон энэхүү гэрээний нэгдүгээр хавсралт;
2. иргэн-даатгуулагчийн хүсэлтээр үзүүлэх нэмэлт үйлчилгээний талаарх мэдээлэл бүхий энэхүү гэрээний хоёрдугаар хавсралт;
3. гэрээг дүгнэхэд харгалзах тусламж, үйлчилгээний тоо болон чанарын шалгуур үзүүлэлтийг хэмжих энэхүү гэрээний гуравдугаар хавсралт;
4. талуудын харилцах сувгийг тодорхойлсон дөрөвдүгээр хавсралт;

...../эрүүл мэндийн тусламж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн нэр/-ИЙН ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭ, ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Тусламж, үйлчилгээ ний төрөл	ОХБ код	ОХБ- ийн нэр	ОХБ /ОУӨА 10	ОХБ -ын үйлдлийн ангилал	ОХБ -ын үйлдэл /ОУҮА 9/	Өртгийн жин	ЭМДҮЗ-ийн тогтоолоор баталсан төлбөрийн хэмжээ, төгрөгөөр				..... онд төлөвлөсөн тоо хэмжээ		Гэрээгээр тохиролцсон эрүүл мэндийн даатгалын зарим тусламж, үйлчилгээний тариф болон тухайн тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээний зөрүү төлбөр	
								Нийт төлбөр	Хамтын төлбөр төлөх иргэн		Хамтын төлбөрөөс чөлөөлөгдөх иргэн		Боломжит дээд хэмжээ		Заавал үзүүлэх тоо хэмжээ
									ЭМД- аас төлөх	Иргэнээс төлөх	ЭМД-аас төлөх	Иргэнээс төлөх			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16

1 дүгээр хавсралт

2 дугаар хавсралт

...../эрүүл мэндийн тусламж, эрүүл мэндийн тусламж,  
үйлчилгээ үзүүлэгчийн нэр/-ЭЭС ИРГЭН/ДААТГУУЛАГЧИЙН  
ХҮСЭЛТЭЭР ҮЗҮҮЛЭХ НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

Орны төрөл	Өрөөний тоо	Орны тоо	Нэмэлт үйлчилгээний төлбөр
VIP			
1 ортой			
2 ортой			
3 ортой			
Нийт			

## 3 дугаар хавсралт

...../эрүүл мэндийн тусламж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн нэр/-тэй  
 БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1117148846  
 ТУ30845.2.5264708

А. Нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тодорхойлолт/Аргачлал	Тайлбар	Олон улсын дундаж хэмжээ	Суурь түвшин	Хүрэх түвшин	Нийт гэрээнд эзлэх хувийн жин /оноо	Үнэлэх аргачлал	Мэдээллийн эх сурвалж
1	Uptodate тогтмол ашигладаг эмчийн хувь	Uptodate-д сард 2 ба түүнээс дээш удаа хандалт хийж, шаардлагатай материал уншсан эмчийн тоо*100% / Нийт эмчийн тоо	Төрийн өмчит ЭМБ-д хамаарна.	≥ 85%	Байгууллага бүрийн суурь түвшинг гэрээнд тусгана.	≥ 40 %	10 оноо	Хүрэх түвшинд хүрсэн бол 10 оноо, хүрээгүй бол 0 оноо	Валтерс клуверийн тайлан
2	Кесар мэс заслын хувь	Кесар мэс засал хийлгэсэн тохиолдлын тоо*100% / нийт төрөлтийн тоо	Аймгийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн эмнэлэг, тусгай эмнэлэг болон төрөх, эх барихын чиглэлийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн нэгдсэн	≤ 25%	Байгууллага бүрийн суурь түвшинг гэрээнд тусгана.	≤25%	10 оноо	Хүрэх түвшинд хүрсэн бол 10 оноо, хүрээгүй бол 0 оноо	ЭМДЕГ азрын нэхэмжлэлийн дата



## 4 дүгээр хавсралт

ТАЛУУДЫН ХАРИЛЦАХ СУВАГ

2  
1117148046  
 ТУ30845 X 5284708

Харилцах асуудал	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчийн:	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн:
<b>1. Цахим хаяг:</b>		
Тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, өртөг зардал, төлбөрийн аргын асуудлаар		
Сонгон шалгаруулалт, гэрээлэлт, гэрээний үр дүнгийн хяналтын асуудлаар		
Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын асуудлаар		
Санхүүжилт, төлбөр тооцоотой холбоотой асуудлаар		
Програм хангамжийн асуудлаар		
Бусад нийтлэг асуудлаар		
<b>2. Шуудангийн хаяг:</b>		

Гэрээтэй холбогдох асуудлаар зөвхөн **АЛБАН ЁСНЫ** хүрээнд харилцана. Үүнд:



Шуудангаар  
илгээсэн албан  
бичиг



Цахимаар илгээсэн  
албан бичиг



Төлбөрийн  
нэхэмжлэл



Тэмдэглэлээр  
баталгаажсан  
уулзалт



4 дүгээр хавсралтад заасан  
харилцах суваг



# ЭМТҮ худалдан авах гэрээний загварт орсон НИЙТЛЭГ ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

**1**

Талуудын харилцах сувгийг гэрээнд тодорхой тусгасан  
/Лавлагаа – 4 дүгээр хавсралт, анхан – 3 дугаар хавсралт/

**2**

**Худалдан авах т.ү-ий төрөл, тоо хэмжээг тохирох**

- 1 дүгээр хавсралт
- Анхан шатны ЭМБ-ын хувьд зөвхөн ЭМД-ын 4 тусламж, үйлчилгээ дээр хийх

**3**

**Урьдчилгаанд олгох хувь хэмжээг бууруулах**

- Лавлагаа – 50 хүртэл хувь
- Анхан шатны 1 иргэний санхүүжилт – 80 хувь, ЭМД-ын 4 тусламж дээр 70 хүртэл хувь

**4**

**ЭМД-ын байгууллагын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлсэн.**

- Төлбөрийн нэхэмжлэлийн хяналтын тайлан, эрүүл мэндийн байгууллага дээр хийх хяналт, гэрээний хэрэгжилтийг хянасан тухай дүгнэлт, эмнэлзүйн аудит хийсэн шинжээчийн дүгнэлтийг 5 хоногт багтаан ЭМБ-д хүргүүлэх
- Хагас бүтэн жилээр чанарыг сайжруулах зөвлөмж өгөх
- Т.Ү-ий урьдчилгаа болон үлдэгдэл төлбөрийг хугацаандаа төлөөгүй бол мөнгөн хариуцлага хүлээх

## 5

### Зөрчлийг тооцож, нийт нэхэмжлэлийн 10 хувьд хүрвэл гэрээ цуцлах

- хуурамч нэхэмжлэл илгээсэн;
- завших оролдлого хийсэн;
- оношийн код ахиулж нэхэмжилсэн.

## 6

### Шалгуур үзүүлэлт

- Нийт 100 оноо бүхий, цөөн тоотой
- Байгууллагын төрлөөс хамааран ялгаатай
- ЭМД-ын гол зорилгыг хангаж буй эсэхийг хянах зориулттай
- Урамшуулал олгох эсэхийг шийдэх
- ЭМДЕГазрын дата мэдээллээс гарах

## 7

### Урамшуулал

- Гэрээний хэрэгжилт 90 ба түүнээс дээш үнэлгээтэй бол олгох
- ЭМД-ын хуулийн 20.1.3 заалт
- Журам батлагдах шаардлагатай


## Лавлагаа шатлал



Гэрээний хугацааг 3 жил болгосон.



Жил бүр гэрээний хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах



Нэмэлт үйлчилгээний төлбөр, төлбөртэй өрөөг гэрээнд тусгах

## Анхан шатлал



Төр хариуцах т.ү /1иргэн/-ий санхүүжилтийн 20 хувийг санд үлдээж, сар бүрийн эцэст гэрээний үнэлгээ дээр үндэслэн олгох, эсэхийг шийдэх

## ЭМДЕГ




- иргэн, даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.8.6, 14.8.7-т заасан холбогдох журмын дагуу чанарын болон төлбөрийн хяналт хийх;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн иргэн, даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний урьдчилгаа болгож, өмнөх сарын гүйцэтгэлийн 50 хүртэлх хувиар тооцон урьдчилгаа санхүүжилтийг сар бүрийн 11-ний дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид олгох;
- гэрээний 2.1.2-ын дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид олгосон тусламж, үйлчилгээний зардлын урьдчилгаа төлбөр нь шаардлага хангасан нэхэмжлэлийн төлбөрийн дүнгээс давсан тохиолдолд зөрүүг дараа саруудын урьдчилгаа төлбөрөөс суутгах;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдол, шүүхийн маргаан болон хяналтаар зөрчил илрүүлсэн тохиолдолд газар дээрх хяналт хийх, эмнэлзүйн аудит хийж, шинжээчээр дүгнэлт гаргуулах зэрэг хяналтын үйл ажиллагаанаас холбогдох арга хэмжээг авах;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс холбогдох хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт, мэдээллийг шаардаж гаргуулах;

## ЭМДЕГ

1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.8.6, 14.8.7-т заасан холбогдох журмын шалгуурыг хангаагүй тусламж, үйлчилгээний тохиолдлын төлбөрийг санхүүжүүлэхгүй байх
2. дараах тохиолдолд холбогдох баримт, нотолгоог үндэслэн тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийг хянах болон санхүүжүүлэхээс татгалзах:

1. гэрээний 3.6.1, 3.6.3, 3.6.4, 3.6.5, 3.6.6-т заасан шалтгаанаар гэрээ түдгэлзүүлсэн, гэрээний 3.6.2-т заасан шалтгаанаар гэрээг түдгэлзүүлэн шалгахад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн буруутай нь нотлогдсон тохиолдолд энэ хугацаанд харгалзах тусламж, үйлчилгээний нэхэмжлэл
2. гэрээний нэгдүгээр хавсралтаар баталсан тоо хэмжээнээс хэтэрсэн нэхэмжлэл;
3. гэрээний 2.4.1-т заасан хугацаанаас хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоцроосон нэхэмжлэл;
4. тусгай зөвшөөрөлд заасан хаяг, байршлаас өөр хаяг байршилд үйлчилгээ үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэхэмжлэл;
5. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрөл эсхүл магадлан итгэмжлэлийн хугацаа нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр сунгагдахдаа уг хугацаа дуусгавар болсон өдрөөс нөхөж сунгагдсан тохиолдолд дээрх хугацаан дахь тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэл;





## ЭМДЕГ



1. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн нэхэмжлэлийг хянаж, хяналтын үр дүнд суурилан шаардлага хангасан нэхэмжлэлийн төлбөрийн хэмжээг тогтоох;
2. гэрээний 2.2.1-т заасан тооцооны үр дүнд үндэслэн нэхэмжлэлийн хяналт дууссанаас хойш холбогдох журамд заасан хугацаанд багтаан тусламж, үйлчилгээний төлбөрийн урьдчилгаа болон гүйцэтгэлийн зөрүүг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх;
3. а) төлбөрийн нэхэмжлэлийн хяналтын тайлан, б) эрүүл мэндийн байгууллага дээр хийх хяналт, гэрээний хэрэгжилтийг хянасан тухай дүгнэлт, с) эмнэлзүйн аудит хийсэн шинжээчийн дүгнэлт тус бүрийг хяналт дууссанаас хойш ажлын 5 хоногт тус тус багтаан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэх;
4. нэхэмжлэлийн хяналтын талаар болон албан тушаалтны ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн талаар гаргасан гомдлыг гомдол хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан хянан үзэж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид хариу хүргүүлэх;

## ЭМДЕГ



- тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын үр дүнд хагас, бүтэн жилээр дүн шинжилгээ хийж, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид зөвлөмж өгөх;
- эрүүл мэндийн даатгалын цахим мэдээллийн сан, тусламж, үйлчилгээний чанар, зардлын төлбөрийн хяналттай холбоотой журам, шалгуур, аргачлал, удирдамж, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээллийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид тухай бүр хүргүүлэх;
- хөнгөлөлттэй эмийн жор бичих эмчийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, програмд нэвтрэх эрхийг цаг хугацаанд нь нээх;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид эрүүл мэндийн даатгалын мэдээллийн сан руу хандах техникийн боломжийг олгох, системийн хөгжүүлэлт, хэвийн ажиллагааг хангах, мэдээлэл дамжуулах загварыг гаргах;

## ЭМБ



1. шаардлага хангасан нэхэмжлэлийн төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжлэх;
2. тусламж, үйлчилгээний зардалд зориулж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас урьдчилгаа төлбөр нэхэмжлэх;
3. хяналтын тайлан, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд тайлан, дүгнэлт хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт, эрүүл мэндийн даатгалтай холбоотой аливаа асуудлаар холбогдох тайлбар, гомдол, саналаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчид албан бичгээр хүргүүлэх;
4. эрүүл мэндийн даатгалын байгууллагын цахим мэдээллийн сангийн зөвшөөрөгдсөн хэсэгт нэвтрэх, холбогдох мэдээллийг шаардах;

## ЭМБ



- Нэхэмжлэлийн мэдээллийг цахим системээр, албан бичгийг гэрээний баримт бичигт заасан холбогдох хаягаар эсхүл орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсийн албан ёсны цахим хаягаар сар бүрийн 5-ны дотор хүргүүлэх;
- төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн цаглабартай холбогдуулан тухайн төсвийн жилийн 6, 12 дугаар саруудад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгон хуанлийн 2 хоногт багтаан илгээх, 11-ний өдрөөс тухайн сар дуусталх хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг дараа сарын нэхэмжлэлтэй хамтатган хүргүүлэх;
- нарийвчилсан хяналт хийхээр сонгосон түүврийн жагсаалтыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас хүлээн авснаас хойш ажлын 1 хоногт багтаан холбогдох маягтуудын дагуу гаргаж хүргүүлэх;
- тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах зайлшгүй болон нэмэлт шаардлагыг гэрээний хугацаанд хангаж ажиллах. Хэрэв холбогдох шаардлагыг хангах боломжгүй болсон тохиолдолд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчид мэдэгдэж, холбогдох арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлэх;



## ЭМБ



- хяналт шалгалт хийхэд шаардагдах баримт, нотолгоо, мэдээллийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчид саадгүй гаргаж өгөх;
- гэрээний 2.4.1, 2.4.5-д заасны дагуу гаргаж өгсөн мэдээлэл болон иргэн, даатгуулагчийн талаарх цахимаар илгээсэн мэдээллийн үнэн, зөв байдлыг бүрэн хариуцах;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас тогтоосон шаардлагад нийцүүлж цахим системээр мэдээлэл солилцох техникийн боломж бүрдүүлэх;
- иргэн даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын мэдээллийг цахим системээр үнэн зөв алдаагүй илгээх;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой хууль, тогтоомж, эрх зүйн акт болон даатгалаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээ, түүний төлбөрийн мэдээлэл зэргийг шинэчилэгдсэн тухай бүр иргэдэд ил тод мэдээлдэг байх;



## ЭМБ



- иргэн, даатгуулагчийн эрүүл мэндийн болон тусламж, үйлчилгээний мэдээллийн нууцлалыг хадгалах;
- иргэнээс гэрээний 1, 2 дугаар хавсралтаар баталсан “Иргэний хариуцан төлөх төлбөр”-өөс өөр нэмэлт төлбөр авахгүй байх;
- мэс засал, төрөх, эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээнээс олсон орлогын тодорхой хувийг эмнэлгээс шалтгаалах халдвар (MRSA) илрүүлэхэд зарцуулах, энэ тухай тайланг худалдан авагчид гэрээ дүгнэхээс 1 сарын өмнө хүргүүлэх;
- амь тэнссэн үеийн яаралтай тусламжийг шаардлагатай хүнд аливаа төлбөргүй, эрүүл мэндийн даатгал шаардахгүйгээр үзүүлэх;

# Гэрээнд өөрчлөлт оруулах

01

Эрх бүхий этгээдээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийн хэмжээг өөрчлөх шийдвэр гаргасан



02

- Тусламж, үйлчилгээ шинээр үзүүлэх, эсхүл үзүүлэх боломжгүй болсон
- Хуульд заасан бусад Үндэслэл





# Гэрээг түдгэлзүүлэх





# Гэрээг цуцлах, дуусгавар болгох

## Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах:

- Гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн **70** буюу түүнээс дээш хувийг хангаагүй.
- Дараах зөрчлийн тохиолдол нийлбэр дүнгээрээ тухайн хугацаанд ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийн **10** хувьд хүрсэн бол:
  - хуурамч нэхэмжлэл илгээсэн
  - завших оролдлого хийсэн
  - оношийн код ахиулж нэхэмжилсэн
- Гэрээг түр түдгэлзүүлсэн хугацаанд тавьсан шаардлагыг тогтоосон хугацаанд хангаагүй
- Хяналт шалгалтад саад учруулсан, зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, худлаа баримт бичгээр хангасан, хяналт шалгалтад нөлөөлөхийг оролдсон, хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг арилгаагүй, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, дахин давтан зөрчил гаргасан

## Гэрээ дуусгавар болох:

- Талууд гэрээг харилцан тохиролцсоны үндсэн дээр дуусгавар болгож болно.





## Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн хүлээх хариуцлага:

- Газар дээр нь хийх хяналт, шалгалтын тусгай шаардлага хангаагүй, хуурамчаар бичиг баримт бүрдүүлснээр гэрээг түр түдгэлзүүлсэн бол өмнөх хугацаанд төлсөн төлбөрийг нөхөн суутгаж, хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувиар алданги тооцно.
- Зардлын нэхэмжлэлийг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас биелүүлээгүй тохиолдолд хоцроосон хоног тутамд холбогдох төлбөрийн нэхэмжлэлийн дүнгийн 0.5 хувиар тооцож суутгана.
- Эмнэлзүйн аудитын дүгнэлтээр буруутай нь нотлогдсон тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээний төлбөрийг нөхөн суутгана.
- Иргэн, даатгуулагчаас хууль бус төлбөр авсан нь тогтоогдвол төлбөрийг буцаан төлүүлж, хууль бус төлбөрийн хэмжээтэй дүйцэх санхүүжилтийг дараагийн санхүүжилтээс бууруулна.
- Хөнгөлөлттэй эмийн жор бичих эрхгүй эмчээр жор бичүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад холбогдох хууль, журмын дагуу торгууль ногдуулна.
- Гэрээг хугацаанаас нь өмнө цуцласан бол тухайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч дахин сонгон шалгаруулалтад оролцож, гэрээ байгуулах мэдэгдэл хүлээн авах хүртэл гэрээ байгуулах эрхгүй байна.





The logo for the Asian Development Bank (ADB) is displayed in white serif font on a dark blue square background. A thin white vertical line is positioned to the right of the square.

ADB

**ДААТГУУЛАГЧДАД ЭМИЙН ҮНИЙН  
ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ  
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ  
ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

01

Үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн хувь хэмжээг мөрдөөгүй бол **Гэрээ цуцлах**

- Иргэнээ санхүүгийн эрсдэлээс хамгаалах

Зөрчилтэй нэхэмжлэлийн хувь 10 хувьд хүрсэн бол **Гэрээ цуцлах**

- Зөрчлийг хязгаарлах

03

02

Эмийн сангийн ү.а-д гэрээгээр хориглосон үйл ажиллагааг явуулсан тохиолдолд **Гэрээг цуцлах**

- Хариуцлагыг нэмэгдүүлэх

04

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хийх гэрээнээс ялгаатай нь **Урамшуулал олгохгүй.**

Зах зээлд гаргах зөвшөөрөлгүй, улсын бүртгэлд бүртгүүлээгүй, хуурамч, чанарын баталгаагүй, хугацаа дууссан эмээр үйлчлэх

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг зөрчин зар сурталчилгаа явуулах, тулган шаардах, буруу ташаа мэдээлэл өгөх, үйлчлүүлэгчийн сонгох боломжийг хязгаарлах

1

2

3

4

5

Эм барих эрх, зөвшөөрөлгүй этгээдийг эм найруулах, бэлтгэх, шалгах, олгох үйл ажиллагаанд оролцуулахгүй байх

Ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор эмчээр эм борлуулах, үр дүнгээр урамшуулах, түүнтэй адилтгах үйл ажиллагаанд татан оролцуулах, үгсэн хуйвалдах

Эмийн сангийн стандарт, санхүүгийн болон хүний нөөц, бусад асуудлаар худал мэдээлэл ирүүлэх, даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх,



**АНХААРАЛ  
ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА**